

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 01

Улаанбаатар

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2017 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд, тус компани нь 2017 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зохих түвшинд явагдсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Европын сэргээн босголтын хөгжлийн банкнаас авсан зээлийн гэрээний үүрэг бүрэн биелээгүйгээс санхүүгийн байдал зохих түвшинд хүрч сайжраагүйг тэмдэглээд:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 02

Улаанбаатар

Компанийн дүрмийн зарим заалтыг хасч,
шинэчлэн батлах тухай

Компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэр, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрмийн 9.3 дахь заалтанд “Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно” гэсэн заалтыг хасч, “Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллахыг хориглох бөгөөд ТУЗ-ийн гишүүн байж болно” гэсэн өөрчлөлт оруулж баталсугай.

ДАРГА  Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 4 сарын 26

дугаар 03

Улаанбаатар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2018 оны зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ